



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

Ус зайлуулах шугам сүлжээнд үзлэг шалгалт
явуулах ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 1 дүгээр хэсгийн 1.3, 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Зам талбайн борооны ус зайлуулах инженерийн шугам сүлжээ, үерийн ус өнгөрүүлэх далан сувгийн ашиглалтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, мөн 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн үерийн нөхцөл байдалд дүгнэлт гаргаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан 2017 оны Улс, нийслэлийн төсөвт хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх ажлын санал зөвлөмж гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Б.Цэрэнбалжид	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын Дэд бүтцийн хэлтсийн дарга
Гишүүд	Н.Мөнхбаяр	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Газар чөлөөлөх хэлтсийн дарга
	Э.Эрдэнэбаатар	Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшигийн шуурхай удирдлагын хэлтсийн Гамшгаас хамгаалах албад, хариуцсан ахлах мэргэжилтэн, нийслэлийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга
	Б.Бумням	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын Дэд бүтцийн хэлтсийн мэргэжилтэн
	С.Баяр-Өлзий	"Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГазрын Ерөнхий инженер бөгөөд Шуурхай удирдлагын төвийн дарга
	Б.Батсүх	"Ус сувгийн удирдах газар" ОНӨҮГазрын Дэд дарга бөгөөд Ерөнхий инженер
	Д.Бауыржан	"Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв" ОНӨААТҮГазрын Шуурхай ажиллагааны албаны Ахлах диспечир инженер

1110300432

	Б.Ганбагана	Нийслэлийн Авто замын газрын Төлөвлөт судалгааны хэлтсийн Авто замын төлөвлөлтийн мэргэжилтэн
	Б.Марина	Нийслэлийн Авто замын газрын Төлөвлөт судалгааны хэлтсийн Газар чөлөөлөлт, инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Ч.Рэгзмаа	Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” ОНӨҮГазрын Ерөнхий инженер
	М.Мэндбаяр	Баянзүрх дүүргийн Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн Гэрэлтүүлэг, хот тохижилт хариуцсан мэргэжилтэн
	Ц.Баттөмөр	Сүхбаатар дүүргийн Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дарга
	Т.Сүхбаатар	Сонгинохайрхан дүүргийн Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дарга
	Б.Батбаяр	Баянгол дүүргийн Дэд бүтэц, тохижилтын Байгаль орчин, орчны бохирдол, хог хаягдал хариуцсан мэргэжилтэн
	А.Гэрэлт-Од	Чингэлтэй дүүргийн Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дарга
	Б.Даваажав	Хан-Уул дүүргийн Дэд бүтэц, тохижилтын хэлтсийн дарга
	Ц.Баярмаа	“Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГазрын Шуурхай удирдлагын төвийн Шугам сүлжээний ахлах инженер
	Л.Эрдэнэхүү	“Орон сууц, Нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГазрын Техник, хяналтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга	М.Балдандорж	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн

2. Ус зайлуулах шугам сүлжээнд үзлэг шалгалт зохион байгуулах ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.


3. Ус зайлуулах шугам сүлжээнд үзлэг шалгалт зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу дээрх ажлыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсэг /Б.Цэрэнбалжид/-т үүрэг болгосугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



УХА0501 9077367

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2016 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн
А/98 дугаар тушаалын хавсралт



УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ СҮЛЖЭЭНД ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Улаанбаатар хотын Зам талбайн борооны ус зайлуулах инженерийн шугам сүлжээ, үерийн ус өнгөрүүлэх далан сувгийн ашиглалтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, мөн 2016 оны 07-р сарын 28-ны өдрийн үерийн нөхцөл байдалд дүгнэлт гаргаж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан 2017 оны Улс, нийслэлийн төсөвт хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх ажлын санал зөвлөмж гаргах.

Хоёр. Үзлэг хийх хугацаа ба хамрагдах барилгууд.

Үзлэг, шалгалтыг 2016 оны 08 дугаар сарын 02-оос 2016 оны 08 дугаар сарын 09-ний хооронд Нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай үерийн хамгаалалтын барилга байгууламж, далан сувгийн дагуух барилга байгууламжид явуулна.

Гурав. Үзлэг хийх бүрэлдэхүүн.

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтэс
- Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар
- Нийслэлийн Өмчийн харилцааны газар
- Нийслэлийн Онцгой байдлын газар
- Нийслэлийн Авто замын газар
- “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв” ОНӨААТҮГ
- “Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ
- “Орон сууц, Нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨҮГ
- “Ус Сувгийн удирдах газар” ОНӨҮГ
- “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” НӨҮГ
- Баянзүрх дүүрэг
- Баянгол дүүрэг
- Сонгинохайрхан дүүрэг
- Сүхбаатар дүүрэг
- Чингэлтэй дүүрэг
- Хан-Уул дүүрэг

Дөрөв. Үзлэг хийх чиглэл.

Улаанбаатар хотын Зам талбайн борооны ус зайлуулах инженерийн шугам сүлжээ, үерийн ус өнгөрүүлэх далан сувгийн ашиглалтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт гаргах,

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн гаргасан 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 102 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламж, борооны болон хөрсний ус зайлуулах шугамын хамгаалалтын зурвас, засвар үйлчилгээний журмын хэрэгжилтийн биелэлт,

Нийслэлийн Онцгой комиссын 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлаас өгөгдсөн 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдөр болсон үерт үнэлэлт дүгнэлт өгөх, 2017 оны Улс, нийслэлийн төсөвт хөрөнгө оруулалтын ажлын санал, зөвлөмж ирүүлэх,

Улаанбаатар хотод Шинээр баригдаж байгаа барилга байгууламж, зам талбайг байнгын ашиглалтад хүлээж авахдаа дээврийн болон гадна талбайн усыг зайлуулах инженерийн шугам сүлжээг хийлгүүлж, төвийн шугам сүлжээнд холбуулан хүлээн авах, Мөн одоо ашиглагдаж байгаа барилга байгууламжийн зам талбайн болон дээврийн усыг төв шугам сүлжээнд холбуулах арга хэмжээний санал боловсруулж танилцуулах

Тав. Үзлэгийн дүнг тайлагнах.

Ажлын хэсгийн хийсэн үзлэг шалгалтын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж танилцуулга